



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны  
зохицуулалтын журам, заавар батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх заавар"-ыг 2 дугаар хавсралтаар, "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичиг хүлээн авах, хянах заавар"-ыг 3 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.


2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Хорооны 2015 оны "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, заавар батлах тухай" 409 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮҮШЭТЭГЧ  
ДЭД ДАРГА  БАТБОЛД



Санхүүгийн зохицуулах хорооны  
2016 оны 4-дугаар сарын 11-ний өдрийн  
71 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт



**БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ,  
ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛИЙН МАЯГТ БӨГЛӨХ, БАРИМТ БИЧГИЙГ  
БҮРДҮҮЛЭХ ЗААВАР**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Энэхүү зааврын зорилго нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягтыг бөглөх, тэдгээрт хавсаргах баримт бичгийг бүрдүүлэхэд банк бус санхүүгийн байгууллага /цаашид ББСБ гэх/, тэдгээрийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, удирдлагуудад мөрдлөг болгон ашиглахад оршино.

**Хоёр. Тусгай зөвшөөрлийн маягт бөглөх,  
баримт бичиг бүрдүүлэх**

А.Тусгай зөвшөөрлийн СЗХ02001 маягтыг бөглөх заавар

Үүсгэн байгуулагч нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдээ улсын бүртгэлд бүртгүүлсний дараа банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/-нд хандана.

Тусгай зөвшөөрлийн өргөдлийн маягтыг Хорооны вэбсайт дахь "online" өргөдлийн маягт цонхонд хандаж цахимаар бөглөнө. Өргөдлийн маягтыг цаасаар бөглөх тохиолдолд Хорооны вэб сайтаас татаж авна.

Маягтыг бөглөхдөө техникийн үзүүлэлт, компанийн хэлбэрээс бусад тохиолдолд товчлол хэрэглэхгүй, иргэний овог нэр, оноосон нэр, он сар өдрийг бүтэн бичиж, сонгох тохиолдолд тохирох нүдэнд "✓" тэмдгийг тавина.

1. Өргөдөл гаргасан огноо: Он, сар, өдөр гэсэн дарааллаар тоогоор бичнэ.

2. Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн нэр: Үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн оноосон нэр, Улсын бүртгэлийн дугаар, Регистрийн дугаар бичнэ.

Хэсэг 1. Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны төрлөө сонгоно.

Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны төрлийг сонгохдоо: Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1-д заагдсан тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрлийг сонгоно.

Хэсэг 2. Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл

1. Өмнө нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байсан бол тийм гэсэн сонголт, явуулж байгаагүй бол үгүй гэсэн сонголтыг хийнэ.

2. Бизнесийн аль салбарт, ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан тухайгаа товч бичнэ.

3. Өмнө нь тусгай зөвшөөрөл хүсч ирүүлж байсан бол тийм гэсэн сонголт, ирүүлж байгаагүй бол үгүй гэсэн сонголтыг хийнэ.

4. Тусгай зөвшөөрөл хүсч байсан бол хэдэн онд, Хорооноос ямар шалтгаанаар татгалзсан тухай товч бичнэ.

5. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагдсан огноо, хуулийн этгээдийн хэлбэр, хөрөнгө оруулалтын хэлбэр, хаяг байршил, цахим хаяг зэрэг үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг асуулгын дагуу нөхнө.

6. Шинээр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн дансны мэдээллийг оруулахдаа дансны төрлийг сонгож, банкны нэр, дансны дугаар, валютын төрөл бүрээр банкин дахь харилцах, хадгаламжийн дансны үлдэгдлийг нөхнө.

7. *Тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээллийг бөглөхдөө:* Хуулийн этгээд, иргэнээс оруулсан хувь хөрөнгийн хэмжээг хувьцааны тоо, хэмжээ, хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь тус бүрээр хүснэгт дэх асуулгын дагуу нөхнө. Хувь нийлүүлсэн хөрөнгө нь Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээг хангасан байх бөгөөд хууль ёсны үйл ажиллагааны орлогоос бүрдсэн байна.

Хэсэг 3. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулагч нь хуулийн этгээд, иргэний аль нь болохыг тодорхойлж, тохирох нүдэнд “✓” тэмдгийг тавина.

1. *Үүсгэн байгуулагч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн талаарх мэдээлэл:*

1.1. Оноосон нэр: Монгол – хуулийн этгээдийн нэрийг кирилл үсгээр, бүтэн бичнэ.

Англи – хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ.

1.2. Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн дугаар, Регистрийн дугаарыг бичнэ

1.3. Хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан огноог он, сар, өдөр гэсэн дарааллаар бичнэ.

1.4. Хуулийн этгээдийн хэлбэр: ХК-Хувьцаат компани, ХХК-Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нь болохыг сонгоно.

1.5. Хөрөнгө оруулалтын хэлбэрээс тохирох нүдийг сонгоно. Гадаадын хөрөнгө оруулалттай компани гэдэгт нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 мянган ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуй нэгжийг ойлгоно.

1.6. Бизнесийн салбар, үйл ажиллагааны чиглэл: Үүсгэн байгуулагч хуулийн этгээд нь бизнесийн аль салбарт, ямар чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг болохоо бичнэ.

1.7. Үйл ажиллагааны орлого, ашиг: Санхүүгийн тайлангаарх орлого, зардал, татвар төлсний дараах цэвэр ашгийн дүнг төгрөгөөр бичнэ.

1.8. Хуулийн этгээдэд оруулах хувь нийлүүлсэн хөрөнгө: Үүсгэн байгуулагч хуулийн этгээдээс оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг төгрөгөөр бичнэ.

1.9. Хаяг байршил: Хуулийн этгээдийн одоо байршиж байгаа эсхүл байршихаар гэрээ байгуулсан байрны хаягийг хүснэгт дэх асуулгын дагуу дэлгэрэнгүй бичих бөгөөд хаяг байршлыг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлсэн байна.

1.10. Холбоо барих утас: Хуулийн этгээдийн холбоо барих суурин, гар утас, факсны дугаарыг бичнэ.

1.11. Цахим хаяг, цахим хуудас: Хуулийн этгээдийн албан ёсны цахим хаяг, хуудсыг бичнэ./Цахим хуудасгүй бол бөглөх шаардлагагүй/.

*Үүсгэн байгуулагч хуулийн этгээдийн компанийн нэгдлийн талаарх мэдээллийг бөглөхдөө:*

1.12. Компанийн нэгдэлд хамрагддаг эсэхийг тодорхойлж, тийм, үгүй гэсэн сонголтоос тохирох нүдийг сонгоно.

1.13. Нэгдэлд оролцогч компаниудын оноосон нэр: Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх хуулийн этгээдийн нэр /гадаадын хуулийн этгээд бол тухайн гадаад улсын зохих байгууллагаас олгосон гэрчилгээн дэх нэр/, Регистрийн дугаарыг бичнэ.

1.14. Компанийн хэлбэр: Хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нь болохыг сонгоно.

1.15. Тусгай зөвшөөрөл хүсэгч компанитай ямар холбоотой болох талаартолгой, хараат, охин, зэргэлдээ гэсэн нүднээс сонгоно.

1.16. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагдсан огноог он, сар, өдөр гэсэн дарааллаар бичнэ.

1.17. Нэгдэлд оролцогч компаниудын эрхэлж буй үйл ажиллагааны төрлийг бичнэ.

1.18. Байгууллагын хаяг, утас, цахим хуудас/цахим хуудасгүй бол бөглөх шаардлагагүй/, цахим шуудангийн хаяг зэрэг мэдээллийг хүснэгтэд оруулна.

*2. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь иргэн бол тэдгээрийн талаарх мэдээлэл:*

2.1. Иргэний овог нэр, регистрийн дугаар, засаг захиргааны бүртгэлтэй албан ёсны хаяг байршил, ажил эрхлэлт, мэргэжлийн талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу бичнэ.

*Үүсгэн байгуулагч иргэн бүрээр хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээллийг бөглөхдөө:*

2.2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг төгрөгөөр, харилцах, хадгаламжийн дансны үлдэгдлийг тухайн валютаар нь өргөдөл гаргах өдрийн үлдэгдлээр бичнэ.

Хэсэг 4. Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл

*Тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн удирдлага, боловсон хүчинтэй холбоотой мэдээллийг бөглөхдөө:*

1. Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, дотоод хяналтын нэгжтэй эсэх талаар хариултыг сонгон, тэдгээрийн бүрэлдэхүүний тоог бичнэ.

2. Ажилтан, албан хаагчдын тоо хэсэгт хуулийн этгээдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах болон ажиллаж буй нийт ажилтны тоог бичнэ.

3. Удирдах албан тушаалтнуудын талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу гаргах бөгөөд удирдах албан тушаалтан нь гадаадын иргэн тохиолдолд регистрийн дугаар хэсэгт гадаад паспортын дугаарыг бичнэ.

Тайлбар: Удирдах албан тушаалтан гэдэгт гүйцэтгэх удирдлага, хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагаанд оролцон ажиллах /ажилладаг/ ажилтнуудын мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу нөхөж, тодорхойлолтыг зааврын хавсралтын дагуу гаргах бөгөөд тодорхойлолт гаргасан этгээд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Жич: Хавсралтад сүүлийн 1 жилийн хугацаанд авахуулсан 3\*4 хэмжээтэй цээж зургийг наана.

Хэсэг 5. Үйл ажиллагаа явуулах ажлын байрны мэдээлэл

1. Ажлын байр хэсэгт тухайн ажлын байрыг худалдаж авсан, түрээсэлсэн аль нь болохыг бичих бөгөөд энэ нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх хаяг байршил, дүрэмд тусгагдсан хаяг байршилтай ижил байна.

Хэсэг 6. Ашиглах техник тоног төхөөрөмж, програм хангамжийн мэдээлэл

2. Үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжийг нэр, төрөл бүрээр түүний хүчин чадал, багтаамж, тоо ширхэг, үнийн талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу бөглөх ба тухайн тоног төхөөрөмжийг худалдаж авсан түрээсэлсэн аль нь болохыг тодорхой бичнэ. Тоног төхөөрөмжийн үнэ нь худалдан авсан өртөг байна.

3. Програм хангамжийн зориулалт баганад тухайн програмыг ямар зориулалтаар ашиглах талаар бичнэ. Жишээ нь нягтлан бодох бүртгэл, зээлийн мэдээллийн санд мэдээ өгч, авах, өдөр тутмын мэдээ, мэдээлэл боловсруулах гэх мэт.

4. Хөрөнгийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах үүднээс ажлын байрны харуул хамгаалалтын асуудлыг шийдвэрлэж, холбогдох этгээдтэй гэрээ байгуулсан байна.

Хэсэг 7. Тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх үйл ажиллагааны төлөвлөлт

Тухайн үйл ажиллагааг ямар хүрээнд явуулах, эх үүсвэрийн өртөг, хүлээгдэж буй ашиг, тухайн үйл ажиллагаанаас хүртэх өгөөжийн хэмжээг зэрэгцүүлсэн он, хүснэгтэд заасан үзүүлэлт бүрээр тоон үзүүлэлтийг өссөн дүнгээр бичих бөгөөд энэ нь бизнес төлөвлөгөөнд тусгагдсан дүнтэй ижил байна.

#### Бизнес төлөвлөгөө боловсруулах зөвлөмж

Бизнес төлөвлөгөөг 3-аас доошгүй жилийн хугацаатай боловсруулах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн байна. Бизнес төлөвлөгөө нь эмх цэгцтэй, ойлгомжтой, бүлэг хэсгүүд нь уялдаа бүхий мэдээлэл нь цаг хугацаандаа, үнэн бодитой, үр дүн нь хэмжигдэхүйц байвал зохино. Бизнес төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгасан байна.

## 1. Компанийн танилцуулга

- Компанийн түүх
- Одоогийн явуулж буй үйл ажиллагаа
- Хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшилт
- Бүтэц зохион байгуулалт, удирдлага, хүний нөөц

## 2. Зах зээлийн судалгаа

- Зах зээл, хэрэглэгч, зах зээлийн ерөнхий чиг хандлага
- Бизнесийн хууль эрх зүйн орчин
- Өрсөлдөөн, өрсөлдөгчид
- Бизнес төлөвлөгөө бичих болсон үндэслэлүүд

## 3. Төлөвлөсөн бизнесийн үйл ажиллагаа

- Бүтээгдэхүүн, үйл ажиллагааны төлөвлөгөө
- Маркетингийн төлөвлөгөө
- Менежментийн төлөвлөгөө
- Санхүүгийн төлөвлөгөө
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө
- Эрсдлийн менежмент /бууруулах арга зам

## 4. Санхүүгийн шинжилгээ

### 1. Компанийн танилцуулга

*1.1. Компанийн түүх:* Энэ хэсэгт танай компани анх хэдэн онд байгуулагдсан, ямар бизнес эрхэлж байсан, компанийн түүх, ололт амжилтын талаар дурьдахаас гадна одоогийн явуулж буй үйл ажиллагаа, бизнесийн чиглэл, бүтээгдэхүүн үйлчилгээ, бүтэц бүрэлдэхүүний талаар бичнэ /Өмнө нь үйл ажиллагаа явуулж байгаагүй бол бичих шаардлагагүй/.

*1.2. Одоогийн явуулж буй үйл ажиллагаа:* Хуулийн этгээд бизнесийн аль салбарт ямар чиглэлээр бүтээгдэхүүн үйлчилгээ эрхэлдэг, одоогийн бизнесийн орчин, эзэмшиж буй тоног төхөөрөмж, барилга байгууламж, хөрөнгө оруулалтын хэмжээ, бүтээгдэхүүн үйлчилгээний тоо хэмжээ, нийлүүлэгч, хамтран ажилладаг байгууллага, харилцагчдын талаарх мэдээллийг бичнэ. /Өмнө нь үйл ажиллагаа явуулж байгаагүй бол бичих шаардлагагүй/

*1.3 Хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшилт:* Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгийн талаар дэлгэрэнгүй бичнэ.

*1.4 Бүтэц зохион байгуулалт, удирдлага, хүний нөөц:* Энэ хэсэгт тухайн байгууллагын боловсон хүчний бүтэц, зохион байгуулалт, удирдлагын багийн танилцуулга, тэдний өмнө хийж байсан ажил, ажлын туршлага, одоогийн хариуцан ажилладаг ажлын талаар танилцуулна. Тухайн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг схемчлэн зурж болно. Боловсон хүчний талаар одоо компанид нийт хэдэн хүн ажиллах, тэднээс хэд нь үндсэн ажилчин, хэд нь гэрээт ажилчин байх, тэдгээрийн цалин хөлс, ямар чиглэлийн ажил хариуцдаг, ажилчид дотроо газар, хэлтэс, салбар зэрэгт хуваагддаг эсэх талаар бичнэ. Цаашид ажилчдын тоог нэмэгдүүлэх эсэх талаар тодруулна.

### 2. Зах зээлийн судалгаа

Зах зээлийн байдал, хэрэглэгчид, зах зээлд гарч байгаа ерөнхий чиг хандлага, тухайн бизнесийн хууль эрх зүйн орчин, тухайн салбар дахь өрсөлдөгчдийн талаар мэдээллүүдийг багтаана.

2.1. *Зах зээл, хэрэглэгч, зах зээлийн ерөнхий чиг хандлага:* Энэ хэсэгт зах зээлийн хэмжээ, хэрэглэгчдийн тоо хэмжээ, тухайн хуулийн этгээдийн зах зээлд эзлэх хувь, зах зээлийн өсөлт, ирээдүйн зах зээлийн байдал, зах зээлийн тогтвортой байдал, зах зээлд гарч байгаа ерөнхий чиг хандлагуудыг бичих бөгөөд технологийн хөгжил, байгалийн хүчин зүйлс, хүн амын суурьшилт зэргийг тодруулна.

2.2. *Бизнесийн хууль эрх зүйн орчин:* Тухайн бизнесийг эрхлэхтэй холбоотой хуулиудыг судалсан эсэх, шаардагдах бичиг баримтыг бүрдүүлж баталгаажуулсан эсэх, хууль эрх зүйн орчинд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах арга замыг тодорхой бичнэ.

2.3. *Өрсөлдөөн, өрсөлдөгчид:* Тухайн зах зээл дээрх ижил төрлийн бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо хэмжээ, нэр, байршил, хүчин чадал, зах зээлд эзлэх хувь, давуу болон сул талуудын талаар дурдана. Компанийн дотоод, гадаад хүчин зүйлсийг судалсан SWOT шинжилгээг хийсэн байвал зохино.

Өрсөлдөгчийн нэр	Байршил	Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл	Багцын хэмжээ	Бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ, хүүгийн хэмжээ	Зах зээлд эзлэх байр суурь
Өрсөлдөгч 1					
Өрсөлдөгч 2					
Өөрийнх					

2.4. *Бизнес төлөвлөгөө бичих болсон үндэслэлүүд:* Яагаад шинээр үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгааныг бичиж, зах зээл, өөрийн хүчин чадлын хэмжээг харгалзан тухайн бизнесийг өргөжүүлэх нөөц, боломжийг тодруулна.

### 3. Төлөвлөсөн бизнесийн үйл ажиллагаа:

3.1 *Бүтээгдэхүүн үйл ажиллагааны төлөвлөгөө:* Үйл ажиллагаа эрхлэн явуулснаар тухайн бүтээгдэхүүн үйлчилгээг ямар хэмжээгээр хүргэх, харилцагч, үйлчлүүлэгчдийн цар хүрээг тодорхойлж, тооцооллыг хийнэ.

3.2. *Маркетингийн төлөвлөгөө:* Өмнөх бүлэгт хийсэн зах зээл, хэрэглэгчдийн судалгааг үндэслэн боловсруулна. Үүнд зах зээлээ сонгох, бүтээгдэхүүн үйлчилгээг идэвхжүүлэх үйл ажиллагаа орно. Маркетингийн төлөвлөгөө нь маркетингийн иж бүрдлээс бүрдэнэ. Үүнд: бүтээгдэхүүн (үйлчилгээ), үнэ (үнийг хэрхэн тогтоох), байрлал (суваг, хуваарилалт), идэвхжүүлэлт (зар сурталчилгаа) зэргийг хэрхэн шийдвэрлэсэнээ тодорхойлно.

3.3. *Менеджментийн төлөвлөгөө:* Байгууллагын удирдлага, бүтэц, зохион байгуулалт, удирдах ажилтан бүрийн хариуцлага, ажилчдын нэрс, цалингийн зардлыг тодорхой бичиж, боловсон хүчнийг бэлтгэх, чадваржуулах шаардлага, тэдгээрт хийх сургалтын талаар тодруулна.

3.4. *Санхүүгийн төлөвлөгөө:* Санхүүгийн төлөвлөгөөнд бизнесийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, орлого, зардал, ашиг, алдагдлыг тооцож, түүнийг хэрхэн удирдах талаар тусгана.

Орлогыг тооцохдоо тухайн орлогыг бүрдүүлэх эх үүсвэр бүрээр тооцож нэгтгэн гаргана.

Зардлыг тооцохдоо бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбогдон гарах, удирдлага зохион байгуулалттай холбоотой, эх үүсвэр татах / зээл, хүү/, албан татвар хураамж төлөх, хөрөнгө оруулалттай холбогдон гарах болон бусад зардал гэх мэтчилэн зардлын зүйл анги бүрээр тооцож, нэгтгэн гаргана.

Мөнгөн урсгалыг тооцохдоо сар бүрийн орж, гарах мөнгөн урсгалыг тооцож, жилээр нэгтгэн гаргана.

Санхүүгийн тайлан баланс зэрэг тоон үзүүлэлтийг бизнес төлөвлөгөөнд тусгахдаа өмнөх онуудын гүйцэтгэлийг ирэх жилийн төлөвлөгөөтэй зэрэгцүүлсэн байдлаар гаргана.

3.5. *Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө*: Шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаа, үүнээс өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс оруулж чадах хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгө оруулалтыг хаанаас авахаар төлөвлөж байгаа /банкны зээл, гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын байгууллагын тусламж, гадаадын банкнаас авах зээл, хувь нийлүүлэгчдийн хөрөнгө оруулалт/-ын талаар бичнэ. Хэрэв өглөг, авлагатай бол энэ талаар жагсаалт үйлдэж, нарийвчлан тодруулсан байна.

3.6. *Эрсдэлийн менежмент бууруулах арга зам*: Бизнес эрхлэхэд олон төрлийн эрсдэл учирч болох бөгөөд техник, санхүү, байгалийн гамшиг, хууль эрх зүй, улс төрийн эрсдэлийг зайлшгүй тооцож өөрийн бизнесийн онцлогт уялдуулан бичнэ. Мөн таны бизнест ямар төрлийн эрсдэл учрах магадлал өндөр болохыг тодорхойлж, эрсдлийг доод хэмжээнд байлгах, түүнээс сэргийлэх, бууруулахын тулд та ямар арга хэмжээ төлөвлөснөө бичих нь зүйтэй. Мөн даатгалд хамруулж болох эрсдэлийг ангилж ямар нөхцлөөр аль даатгалын компанитай гэрээ хийхээ тодорхойлж болно. Харин даатгалд үл хамаарах эрсдэлийн талаар авах арга хэмжээг хэрхэн төлөвлөж байгааг тодорхойлох шаардлагатай.

#### 4. Санхүүгийн шинжилгээ:

Сангийн сайдын 2013 оны 277 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал"-ын дагуу санхүүгийн шинжилгээг хийнэ.

№	Санхүүгийн шинжилгээний төрөл	Тайлбар
✓	Хөрөнгийн бүрэлдэхүүн, динамикийн шинжилгээ	Санхүүгийн байдлын өөрчлөлтийг харуулна.
✓	Төлбөрийн чадварын шинжилгээ	Өр төлбөрөө барагдуулах хугацаа, боломжийг харуулна.
✓	Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ	Хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээ, бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлттэй уялдуулан оршин тогтнох чадварыг харуулна.
✓	Эргэцийн шинжилгээ	Эргэлтийн хөрөнгийн нэг хэлбэрээс нөгөөд шилжих хөдөлгөөнийг илэрхийлэх бөгөөд үр ашиг нэмэгдэх боломжийг харуулна.
✓	Бүтээмжийн шинжилгээ	Хөдөлмөрийн бүтээмжийг харуулна.
✓	Үндсэн хөрөнгийн шинжилгээ	Үндсэн хөрөнгийн ашиглалтын байдлыг харуулна.
✓	Орлого үр дүнгийн шинжилгээ	Орлогын хичнээн хувь нь юунд хэрхэн зарцуулагдсаныг харуулна.
✓	Ашигт ажиллагааны шинжилгээ	Хөрөнгийн нэгж тутмаас олсон ашгийн хэмжээг илэрхийлнэ.
✓	Зах зээлийн идэвхжилтийн шинжилгээ мөнгөн урсгалын шинжилгээ	Компанийн хувьцааны эрэлтийг харуулах бөгөөд хувьцаа эзэмшигч 1 төгрөгийн ашигт хэдэн төгрөг төлж байгааг харуулна.



Мөн түүнчлэн үйл ажиллагаа эрхлэхэд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллах байдал, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрээ нэмэгдүүлэх нөөц, боломж, зах зээлийн хүртээмжтэй байдал, ашигт ажиллагаазэргийг харгалзан үзэж, үр дүнгээ тодорхойлохыг зөвлөж байна.

### Журам, заавар боловсруулах зөвлөмж

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрөл тус бүрт мөрдөж ажиллах журмыг байгууллагын стратеги, зорилготой уялдуулан, Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуульд нийцүүлэн боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

Журам нь дараах үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд үйл ажиллагааны чиглэл, онцлогийг харгалзан зайлшгүй байх асуудал, нийтлэг хэрэглэгддэг нэр томъёо, баримталвал зохих зарчмуудыг тусгасан байна. Үүнд:

- Нийтлэг үндэслэл
- Нэр томъёоны тайлбар
- Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд оролцогч талууд бие биедээ харилцан итгэж, үнэн бодит мэдээллээр хангах, хууль дээдлэх, шудрага байх үндсэн зарчим
- Үйл ажиллагаанд тавигдах шаардлага, хориглох зүйлс
- Талуудын эрх үүрэг
- Гэрээ байгуулах, дуусгавар болох үндэслэл
- Хяналт хариуцлага

Зээлийн хүүгийн хэмжээг тогтоохдоо дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх нь зүйтэй.

$$IR = \frac{FC}{L} + \frac{CC}{L} + \frac{TP}{L} + \frac{OE}{L} + \frac{TC}{L} + \frac{CR}{L} + \frac{RRC}{L}$$

FC	Эх үүсвэрийн зардал
CC	Өөрийн хөрөнгийн зардал
TP	Зорилтот ашиг
OE	Үйл ажиллагааны зардал
TC	Татварын зардал
CR	Зээлийн эрсдэлийн зардал
RRC	Хөрвөх чадварын зохистой харьцааг барих алдагдсан боломжийн зардал
L	Зээлийн хэмжээ

### Баталгаажуулалт

Хүсэлт гаргагч байгууллагыг төлөөлж өргөдлийг үнэн зөв бөглөсөн болохыг баталж, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага өөрийн овог, нэрийг бичиж, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулна.

### Б. Өргөдөлд хавсаргах баримт бичгийг бүрдүүлэх

"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 1 дүгээр хавсралтаар батлагдсан тусгай зөвшөөрлийн СЗХ02001 маягтаар гаргасан өргөдөлд, уг

журмын 2 дугаар хавсралт(А)-д заасан баримт бичгүүдийг дор дурдсан шаардлагын дагуу бүрдүүлж, хавсаргана.

✓ Компанийн тухай хуулийн 14.3 дахь хэсэгт заасны дагуу хийсэн үүсгэн байгуулах хурлын тэмдэглэл, шийдвэрийн эх хувийг ирүүлэхдээ шийдвэрт хуралд оролцсон бүх үүсгэн байгуулагчид гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

✓ Үүсгэн байгуулагчид хамтран ажиллах гэрээ байгуулсан бол гэрээний эх хувийг ирүүлнэ. Гэрээнд үүсгэн байгуулагчдынхүлээх үүрэг, худалдан авах хувьцаа болон бусад үнэт цаасны ангилал, төрөл тус бүрийн тоо, үнэ, худалдан авах хугацаа зэрэг асуудлыг тусгаж, хувьцаа эзэмшигчдийн гарын үсэг, хуулийн этгээдийн тамга тэмдгээр баталгаажуулсан байна.

✓ Тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд бол гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг ирүүлнэ.

✓ Компанийн тухай хуулийн 16.2 дахь хэсэг болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 10 дугаар зүйлд нийцсэн дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталж, дүрмийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг ирүүлнэ.

✓ Хэрэв хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсан байна.

✓ Хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгийг төгрөг эсхүл валютаар тухайн хуулийн этгээдийн банкинд байршуулсан болохыг нотолж, банкны тодорхойлолтыг дансны хуулгын хамт ирүүлнэ.

✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний иргэний цахим үнэмлэх, гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний мэргэжлийн дипломынхуулбарыг нотариатаар гэрчлүүлсэн байна.

✓ Эхлэлтийн тайлан тэнцлийг энэхүү зааврын хавсралтын дагуу гаргана. Бизнес төлөвлөгөөг энэхүү зааврын дагуу боловсруулна.

✓ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1.2-т заасны дагуу хяналт тавих ажилтныг томилох ба дотоод хяналтын хөтөлбөрийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. Хяналт тавих ажилтан нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 1 дүгээр хавсралтаар батлагдсан зөвшөөрлийн СЗХ02001 маягтаар гаргасан өргөдөлд, уг журмын 2 дугаар хавсралт (Б)-д заасан баримт бичгүүдийг дор дурдсан шаардлагын дагуу бүрдүүлж, хавсаргана.

#### 1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зөвшөөрөл нэмж авах

✓ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж авах тухай төлөөлөн удирдах зөвлөлийн хурал /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-аар хэлэлцэж, дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргах ба хурлын тэмдэглэлд хуралд оролцсон төлөөлөн удирдах зөвлөл/ байхгүй бол хувьцаа эзэмшигчид/, шийдвэрт хурлын даргагарынүсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байна.

✓ Банк бус санхүүгийн зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны талаар холбогдох хууль, тогтоомж, журамд нийцүүлэн дүрэмд нэмэлт өөрчлөлтийг оруулж, хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан байна.

✓ Бизнес төлөвлөгөөнд холбогдох өөрчлөлтийг оруулж, хувьцаа эзэмшигчдийн хурлаас батлах бөгөөд бизнес төлөвлөгөө, санхүүгийн үр ашгийн тооцоог СЗХ02001 маягтыг бөглөх зааварт заасны дагуу боловсруулна.

✓ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны журмыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан байна.

### **Гурав. Зөвшөөрлийн өргөдлийн маягт бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх**

#### **А. Зөвшөөрөл хүссэн өргөдлийн СЗХ02002 маягтыг бөглөх**

Маягтыг бөглөхдөө техникийн үзүүлэлт, компанийн хэлбэрээс бусад тохиолдолд товчлол хэрэглэхгүй, оноосон нэр, иргэний овог нэр, он сар өдрийг бүтэн бичиж, сонгох тохиолдолд тохирох нүдэнд “✓” тэмдгийг тавина.

Өргөдөл/хүсэлт гаргагч ББСБ-ын оноосон нэр нүдэнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх оноосон нэр, регистрийн дугаарыг бичнэ.

Зөвшөөрлийнтерлийг сонгохдоо зөвшөөрөл авах төрлөөс тохирохыг нь сонгоно.

Хэсэг 1. Өөрийн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хоёрдогч өглөгийн гэрээгээр эх үүсвэр татахын аль нь болохыг сонгоно.

*Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах*

1. Шинээр хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн оноосон нэр, засаг захиргааны албан ёсны харьяалал, улсын бүртгэлийн гэрчилгээн дэх регистрийн дугаар хуулийн этгээдээс хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнг хувьцааны тоо, хэмжээ, хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь тус бүрээр хүснэгт дэх асуулгын дагуу нөхнө.

2. Шинээр хувьцаа эзэмшигч нь иргэн бол иргэний овог нэр, засаг захиргааны албан ёсны харьяалал, регистрийн дугаар, хувьцаа эзэмшигчээс хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнг хувьцааны тоо, хэмжээ, хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь тус бүрээр хүснэгт дэх асуулгын дагуу нөхнө.

3. Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн болон хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөлтийн талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу нөхөж, нийт хувь хөрөнгөд эзлэх хувийг тодорхойлно. Хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийн гарал үүсэл нь хууль ёсны орлогоос бүрдсэн байна.

*Хоёрдогч өглөгийн гэрээгээр хөрөнгө оруулагчдын мэдээлэл*

1. Хоёрдогч өглөгийн гэрээгээр хөрөнгө оруулагч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээн дэх оноосон нэр, регистрийн дугаар, бүртгэлийн дугаар, засаг захиргааны албан ёсны харьяалал, гэрээнд заасан хоёрдогч өглөгийн хэмжээ, хугацааг бичнэ. Хоёрдогч өглөгийн хугацаа 5 жил байна.

2. Хоёрдогч өглөгийн гэрээгээр хөрөнгө оруулагч нь иргэн бол овог нэрийг бүтэн бичиж, засаг захиргааны бүртгэлтэй албан ёсны харьяалал, регистрийн дугаар, гэрээнд заасан хоёрдогч өглөгийн хэмжээ, хугацааг бичнэ. Хоёрдогч өглөгийн хугацаа 5 жил байна.

*Шинээр хувьцаа эзэмшигч, хоёрдогч өглөгийн гэрээгээр хөрөнгө оруулагчдын компанийн нэгдлийн мэдээлэл хэсгийг бөглөхдөө:*

Шинэ хувьцаа эзэмшигч, хоёрдогч өглөгийн гэрээгээр хөрөнгө оруулагч бүрийн компанийн нэгдэлд хамрагддаг эсэхийг тодорхойлж, тийм, үгүй гэсэн сонголтоос тохирох нүдийг сонгож, хэрэв тийм бол хүснэгт дэх мэдээллийг СЗХ02001 маягтыг бөглөх зааварт заасны дагуу оруулна.

Хэсэг 2. Нэгж байгуулах

*Нэгжийн ерөнхий мэдээлэл хэсгийг бөглөхдөө:*

1. Нэгж байгуулах талаар төлөөлөн удирдах зөвлөл эсхүл хувьцаа эзэмшигчид хуралдаж, шийдвэр гаргах бөгөөд хуралдсан он, сар, өдөр, шийдвэрийн дугаарыг хүснэгтийн дагуу оруулна.

2. Нэгжийн хэлбэрийг сонгож, үйл ажиллагаа явуулах чиглэлийг тодорхой бичнэ.

3. Салбар, нэгжийн хаяг байршлын талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу оруулах ба энэ нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэмд тусгагдсан хаяг байршил байна.

4. Салбарын албан ёсны цахим хуудас, хаягийг бичнэ. Цахим хуудас байхгүй бол бөглөх шаардлагагүй.

*Нэгжийн боловсон хүчний мэдээлэл, салбарын үйл ажиллагааны төлөвлөлт, үйл ажиллагаа явуулах ажлын байр, ашиглах тоног төхөөрөмж, програм хангамжийн мэдээллийг бөглөхдөө:*

СЗХ02001 маягтыг бөглөх зааварт заасан зөвлөмжийн дагуу нөхнө.

Хэсэг 3. Оноосон нэр өөрчлөх

Хуулийн этгээд нь улсын бүртгэлийн гэрчилгээн дэх оноосон нэр, регистрийн дугаар болон хуулийн этгээдийн шинэчилсэн нэр, оноосон нэрээ өөрчлөх болсон шалтгааныг тодорхой бичиж, гүйцэтгэх удирдлагын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулна.

Хэсэг 4. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл сэргээх

Тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн хүрээнд эрхлэх үйл ажиллагааг түдгэлзүүлсэн Хорооны тогтоолын огноо, дугаарыг бөглөнө.

Баталгаажуулалт

Өргөдөл гаргагч ББСБ-ыг төлөөлж өргөдлийг үнэн зөв бөглөсөн болохыг баталж, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага өөрийн овог, нэрийг бичиж, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулна.

Б. Өргөдөлд хавсаргах баримт бичгийг бүрдүүлэх

"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 1 дүгээр хавсралтаар батлагдсан зөвшөөрлийн СЗХ02002 маягтаар гаргасан өргөдөлд, уг журмын 2 дугаар хавсралт(В)-(Ё)-д заасан баримт бичгүүдийг дор дурдсан шаардлагын дагуу бүрдүүлж, хавсаргана.

1. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах

✓ Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах талаар хувьцаа эзэмшигчид хуралдаж дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргах ба хурлын тэмдэглэлд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид, шийдвэрт хурлын даргын гарынүсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байна.

✓ Хувьцаа өмчлөх эрхээ өвлүүлсэн, бэлэглэсэн бол Иргэний хуульд заасны дагуу гэрээ, хэлцэл байгуулж, нотариатаар гэрчлүүлнэ.

✓ Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаагаа худалдахаар санал болгож байгаа хувьцаа эзэмшигч нь уг саналаа ББСБ-д мэдэгдэх бөгөөд энэ тухай бусад хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.

✓ Шинэ хувьцаа эзэмшигчдээс хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь тухайн хувьцаа эзэмшигчийн хууль ёсны үйл ажиллагааны орлогоос бүрдсэн байна.

✓ Хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгийг төгрөг болон валютаар тухайн хуулийн этгээдбанкн дахь өөрийн дансанд байршуулсан болохыг нотолж, банкны тодорхойлолтыг дансны хуулгын хамт авна.

✓ Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлсэн тохиолдолд тухайн жилүүдийн санхүүгийн тайланд аудит хийлгэж, харъяалах татварын байгууллагаар баталгаажуулсан байна.

✓ Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбоотой өөрчлөлт оруулсан дүрэм

## 2. Хоёрдогч өглөг байршуулах

✓ Хоёрдогч өглөг байршуулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргах ба хурлын тэмдэглэлд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид, шийдвэрт хурлын дарга гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байна. Хурлын тэмдэглэл, шийдвэрт эх үүсвэр татах болсон үндэслэлийг тодорхой тусгана.

✓ Хоёрдогч өглөгөөр хөрөнгө оруулагч нь ББСБ-тай харилцан тохиролцож, гэрээ байгуулсан байна. Хоёрдогч өглөгийн гэрээнд хугацааны эцэст хувьцаанд хөрвөх эсэхийг тодорхой заана. Хэрвээ гэрээнд хувьцаанд хөрвөхөөр тодорхой заагаагүй, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гараагүй бол хувьцаанд хөрвөхгүй болохыг анхаарна уу.

✓ Хоёрдогч өглөгөөр хөрөнгө оруулагчийн мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь тухайн хувьцаа эзэмшигчийн хууль ёсны үйл ажиллагааны орлогоос бүрдсэн байна.

## 3. Нэгж байгуулах

✓ Нэгж байгуулах, салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг томилох тухай төлөөлөн удирдах зөвлөлийн хурал /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-аар хэлэлцэж, дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргах ба хурлын тэмдэглэлд хуралд оролцсон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчид/, шийдвэрт хурлын дарга гарынүсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байна.

✓ Нэгж байгуулахтай холбоотой өөрчлөлт оруулсан дүрэм

✓ Нэгжийн үйл ажиллагаанд мөрдөх журмыг боловсруулж, дотоод хяналтын журамд нэмэлт өөрчлөлт оруулан хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн баталсан байна. Дотоод хяналтын журам нь дүрмээр зохицуулагддаг бол дүрэмд нэмэлт өөрчлөлтийг оруулна.

✓ Салбар төлөөлөгчийн газар ажиллах гүйцэтгэх удирдлага нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.5, 13.6-д заасан шаардлагыг хангасан байх ба салбарын гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний иргэний үнэмлэх, мэргэжлийн дипломын хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.

#### 4. Оноосон нэр өөрчлөх

✓ Оноосон нэрийг өөрчлөх талаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, дийлэнхолонхийн саналаар шийдвэр гаргах ба хурлын тэмдэглэлд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид, шийдвэрт хурлын даргагарынүсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байна. Хурлын тэмдэглэл, шийдвэрт оноосон нэрийг өөрчлөх болсон үндэслэлийг тодорхой тусгана.

✓ Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас оноосон нэрийн баталгаажуулалтын хуудсыг авна.

✓ Оноосон нэр өөрчлөхтэй холбоотой өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь

✓ Оноосон нэр өөрчлөхийг зөвшөөрсөн Хорооны шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинээр олгох тул хуучин тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралтын эх хувийг ирүүлнэ.

#### 5. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл сэргээх

✓ Тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн хүрээнд эрхлэх үйл ажиллагааг түдгэлзүүлсэн үндэслэл бүхий зөрчил дутагдлыг арилгаж, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлснийг нотлох баримтыг түдгэлзүүлсэн хугацаанд ирүүлнэ.

### **Дөрөв. Бүртгэлийн өргөдлийн маягт, баримт бичгийг бүрдүүлэх**

#### А. Бүртгэлийн СЗХ02003 маягтыг бөглөх

Өргөдөл/хүсэлт гаргагчийн нэр нүдэнд ББСБ-ын улсын бүртгэлийн гэрчилгээн дэх оноосон нэр, регистрийн дугаарыг бичиж, гүйцэтгэх удирдлага гарын үсэг зурж, хуулийн этгээдийн тамга тэмдгээр баталгаажуулна.

Бүртгүүлэх мэдээллийн төрлийг сонгоно.

Хэсэг 1. Гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт оруулах

Хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын талаарх мэдээллийг хүснэгтэд оруулж, зааврын хавсралтыг нөхнө.

Хэсэг 2. Хаяг байршилд өөрчлөлт оруулах

Өөрчлөлт орсон хаяг байршлын талаарх мэдээллийг хүснэгтийн дагуу бөглөх бөгөөд хаяг байршилыг улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлсэн байна.

#### Баталгаажуулалт


Өргөдөл гаргагч ББСБ-ыг төлөөлж өргөдлийг үнэн зөв бөглөснөө баталж, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага өөрийн овог, нэрийг бичиж, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулна.

#### Б. Өргөдөлд хавсаргах баримт бичгийг бүрдүүлэх

"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 1 дүгээр хавсралтаар батлагдсан бүртгэлийн СЗХ02003 маягтаар гаргасан өргөдөлд, уг журмын 2 дугаар хавсралт(Ж)-д заасан баримт бичгүүдийг дор дурдсан шаардлагын дагуу бүрдүүлж, хавсаргана.

✓ Гүйцэтгэх удирдлага, хаяг байршил өөрчлөх талаар төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчид/ хуралдаж, дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргах бөгөөд хурлын тэмдэглэлд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид, шийдвэрт хурлын дарга гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулна. Хурлын тэмдэглэл шалтгаан, үндэслэлийг тодорхой тусгасан байна.

✓ Гүйцэтгэх удирдлага нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.5, 13.6-д заасан шаардлагыг хангасан байх ба иргэний цахим үнэмлэх, мэргэжлийн дипломын хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.



**ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БОЛОН  
БУСАД БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ**

Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан болон бусад боловсон хүчинндараахмэдээлэл

**1. Ерөнхий мэдээлэл**

Ургийн овог:	
Овог нэр:	
Регистрийндугаар:	
Иргэний харьяалал:	
ББСБ-д эрхлэх албан тушаал:	
Оршин суугаа газрын хаяг	
Гар утасны дугаар	
Цахим хаяг	
Эрхэлжбайгааажил, албан тушаал	
Ажлын хаяг	
Цахим хаяг	

3x4  
Зураг

**2. Боловсрол/Ерөнхийболовсролынсургуулийгоролцууланбичнэ/**

№	Төгссөнсургууль	Эзэмшсэнмэргэ жил	Элссэнон	Төгссэнон	Диплом, гэрчилгээнийдугаар

**3. Ажлынтуршлага**

№	Хаанаажиллажбайсан	Албантушаал	Ажилдорсон он, сар, өдөр	Ажлаасгарса нон, сар, өдөр	Шалтгаан

**4. ТУЗ-ын дарга, гишүүн, гүйцэтгэхудирдлага бусадболовсонхүчнийхолбогдохэтгээдийнбайдал:**

Компанийнтухайхуулийн 89.2-тзаасаннэгдмэлсонирхолтойэтгээдийн мэдээлэл

№	Таныхэнболох	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийндугаар	Эрхэлжбуйажил, албантушаал





ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:

/...../ /...../ /...../ /...../

/Албан тушаал//Овог, нэр/

/гарын үсэг/

ОГНОО



Эхлэлтийн тайлан тэнцлийн загвар

Тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн нэр	
--	--

ХӨРӨНГӨ	ДҮН	ӨР ТӨЛБӨР, ЭЗДИЙН ӨМЧ	ДҮН
<i>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</i>		<i>НИЙТ ӨР ТӨЛБӨР</i>	
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө</i>		<i>Богино хугацаат өр төлбөр</i>	
Бэлэн мөнгө		Дансны өглөг	
Банкинд байгаа мөнгө		Урьдчилж орсон орлого	
Дансны авлага		Бусад	
Бусад санхүүгийн хөрөнгө		<i>Урт хугацаат өр төлбөр</i>	
Урьдчилж төлсөн зардал			
Богино хугацаат хөрөнгө оруулалт		Хойшлогдсон татварын өр төлбөр	
Бусад эргэлтийн хөрөнгө		Бусад урт хугацаат өр төлбөр	
<i>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</i>		<i>ЭЗДИЙН ӨМЧ</i>	
Үндсэн хөрөнгө		<i>Хувь нийлүүлсэн хөрөнгө</i>	
Биет бус хөрөнгө		Нэмж төлөгдсөн капитал	
Урт хугацаат хөрөнгө оруулалт		Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	
Бусад эргэлтийн бус хөрөнгө		Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	
		Тусгай зориулалтын нөөцийн сангууд	
		Хуримтлагдсан ашиг/алдагдал	
Нийт хөрөнгийн дүн		Нийт өр төлбөр ба эздийн өмч	

/..... / /..... / /..... / /..... /

/Албан тушаал//Овог, нэр/

/гарын үсэг/

огноо